



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө аж ахуйн их сургуулийн
Магистр, докторын сургууль

Хөтөлбөрийн нэр: Газар зохион байгуулалт

Индекс: E07

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Гэрэлт-Од
Гишүүд: Ж.Даваабаатар
С.Мөнхнаран

Он сар өдөр: 2021.06.7-8

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн зорилго, агуулга	7
Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	10
Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил	15
Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн	19
Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт	23
Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем	25
Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт	28
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	
I. Оюутнуудын нэрс	34
II. Төгсөгчдийн нэрс	34
III. Ажил олгогчдын нэрс	35
IV. Багш нарын нэрс	35
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	36
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

PLOs	Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар
АЭС	Агроэкологийн сургууль
БШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГЗБ	Газар зохион байгуулалт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГМТ	Газрын менежментийн тэнхим
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
МГЗБХ	Монголын Газар зохион байгуулагчдын холбоо
МДС	Магистр докторын сургууль
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ИДС	Их дээд сургууль
ИС	Их сургууль
IF	Impact Factor
PBL	Problem-based learning
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, Threats

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС-ийн Магистр, докторын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөр	
Индекс	E07310101	
Шинжээчид	<p>Ахлагч: Д.Гэрэлт-Од – ШУТИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга, доктор, дэд профессор</p> <p>Гишүүд: Ж.Даваабаатар – Монголын газар зохион байгуулагчдын холбооны дэд ерөнхийлөгч, доктор</p> <p>С.Мөнхнаран - МУИС-ийн ШУС-ийн Газарзүйн тэнхимийн газар зохион байгуулалтын багш, доктор, дэд профессор</p>	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч - Б.Мядагмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2021.05.12	Тайлан хүлээн авч гэрээ хийсэн
	2021.05.21	Урьдчилсан үнэлгээний тайланг илгээв.
	2021.06.07-08	Сургууль дээр очиж ажилласан
	2021.06.08	Багш, суралцагч, ажил олгогч, төгсөгчидтэй цахим уулзалт хийсэн
	2021.06.	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд өөрсдийн тайланг илгээх
	2021.06.08	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
	2021.06.08	Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол улсад газар зохион байгуулалтын мэргэжилтэн дутагдалтайг анхаарч Шинжлэх ухаан боловсролын сайдын 1996 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 84 тоот тушаалаар Хөдөө аж ахуй их сургуульд Газар зохион байгуулалтын бакалаврын болон магистрын хөтөлбөрийг анх нээсэн. 2001 онд бакалаврын анхны төгсөлт хийгдсэнээр 2001 оны 09 сард анхны магистрын элсэлтээ авч, албан ёсны сургалтаа эхэлсэн.

Газар зохион байгуулалт хөтөлбөрөөр магистрын сургалт явуулж эхэлснээс хойш 20 жилийн хугацаанд нийт 48 магистр төгсөөд байна.

Монгол улсын газрын харилцааны шинэтгэлийн үе болох 1997 онд анхны газар зохион байгуулалтын хөтөлбөрийн элсэлтийг авснаар улсын хэмжээнд дотоодын мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсэн. Тус сургуулийн багш нар газар зохион байгуулалт мэргэжлийн хөтөлбөрийн Монгол улсын стандарт (MNS 5323-б:2004)-ыг анх удаа батлуулсанаар өнөөдрийг хүртэл Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургууль нь Монгол улсын газрын харилцааны салбарын шилдэг сургууль (2014 он), газар зохион байгуулалтын бакалаврын хөтөлбөр нь улсад анх удаа магадлан итгэмжлэгдсэн (2015 он) болно.

Тус хөтөлбөрт хичээл орж буй багш нар 100 хувь докторын зэрэгтэй, салбартаа тэргүүлэгч, зөвлөх инженерийн зэрэгтэй, дэд профессор, профессор цолтой багш нар байна. Туршлагын хувьд боловсролын салбарт 15-аас дээш жил ажилласан туршлагатай багш нар 80-аас дээш хувийг эзэлж байна.

Суралцах хугацаа: 1.5-2 жил

Элсэгчдийн боловсролын шаардлага: Бакалавр

Олгох боловсролын зэрэг: Магистр

Хөтөлбөрийн харьяалах тэнхим: Газрын менежмент

ХААИС-ийн Захирлын 2015 оны 11 сарын 24-ний өдрийн А/377 тоот тушаал “ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”-ыг үндэслэн Газар зохион байгуулалт магистр, докторын мэргэжлийн хөтөлбөрийн хорооны бүрэлдхүүн 8 хүнтэй.

Газар зохион байгуулалтын магистрын хөтөлбөрийн зорилго: Газрын харилцааны ахисан түвшний мэдлэгтэй, орчин үеийн дэвшилтэт технологи, программ хангамжийн тусламжтайгаар газар зохион байгуулалтын салбар шинжлэх ухааны аргазүйг судлах, түүнийг ашиглах, турших чадвартай мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд оршино. Уг зорилгын хүрээнд нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан дараахь зорилтуудыг дэвшүүлсэн.

Зорилт 1. Газар зохион байгуулалтын шинжлэх ухааны арга зүйг эзэмших, тэдгээрийг хэрэглэх, дүн шинжилгээ хийх

Зорилт 2. Салбарынхаа тулгамдаж байгаа асуудалд төрөл бүрийн дүн шинжилгээ, статистик аргуудыг ашиглан, тодорхойлох, шийдвэрлэх арга барилд сургах

Зорилт 3. Судалгаа хийх, судалгааны үр дүнд ирээдүйн таамаглал дэвшүүлэх чадварыг эзэмшүүлэх

Зорилт 4. Орчин үеийн техник технологи, арга, арга зүйг судлах, тэдгээрийг газар зохион байгуулалтад ашиглах, газрын менежментийг эрхлэн явуулах талаар мэдлэг олгох

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

1. БШУС-ын 2014-09-12-ны А/370 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын дагуу боловсруулсан
2. “Газар зохион байгуулалт” магистр докторын хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэрээр батлагдсан
3. Хөтөлбөрийг сайжруулахад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Тэгш хэм групп ХХК, Геоботаник ХХК, Төгсөгчдийн холбоо, Монголын газар зохион байгуулагчдын холбоо зэрэг байгууллага болон төгсөгчдөөс санал авч 2017 онд шинэчлэн боловсруулсан.
4. Төгсөгч нь судлаачийн ёс зүйтэй, газарзүйн мэдээллийн систем болон зайнаас тандан судлалын програм ашиглан байгалийн нөхцөл нөөц, газрын төрөл бүрийн судалгааг орон зайтай уялдуулан дүн шинжилгээ хийдэг, газрын харилцааны асуудлуудыг шийдвэрлэдэг чадвартай байх шаардлага тавьдаг.
5. ХААИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг PDCA мөчлөгийн дагуу 2 жил тутам хийх төлөвлөгөөтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Газар зохион байгуулалт хөтөлбөрийг Монгол улсад анх нээж, мэргэжилтэн бэлтгэсэн анхны их сургууль юм. Мөн энэ мэргэжлийн хөтөлбөрийн MNS 5323-б:2004 стандартыг анх санаачлан боловсруулсан онцлогтой.
- Хөтөлбөрт зөвхөн газрын тухай судлагдахуунаас гадна хөрс, ус зэрэг байгалийн бусад компонентуудтай хамтад нь судладаг хичээлийг оруулж, суралцагчдад өргөн мэдлэг эзэмшүүлдэг нь сайшаалтай.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна..

Илрэл нотолгоо:

1. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 73,3 хувийг ХАА-н газар түүний дотор 90 хувийг бэлчээрийн газар эзэлдэг. Иймээс энэ хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлсон гэж үзэх үндэслэлтэй.
2. Газар зохион байгуулалт"-ын магистрын хөтөлбөрөөр ГЗБ-ын шинжлэх ухааны арга зүй, шинэ техник технологийн мэдлэг эзэмшиж, газрыг төлөвлөх, ашиглах, газрын талаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ур чадвартай, судлаачын ёс зүйг баримтлах, судалгааны үр дүнг нотлох өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх хандлагатай мэргэжилтнийг бэлдэж байна. Энэ мэдлэг, ур чадвар, хандлага нь хөтөлбөрийн зорилготой нийцэж байна.
3. Хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, шинжлэх ухааны магистраар төгсөгчийн загварыг боловсруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөө аж ахуй их сургуульд Газар зохион байгуулалтын магистрын хөтөлбөрийг анх 2001 онд газар байгалийн нөөцийн магистрын анги нээгдэж 09 сард анхны магистрын элсэлтээ авч, албан ёсны сургалтаа эхэлсэн байна. Үүнээс хойш цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан Газар зохион байгуулалтын магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 2003, 2011, 2015, 2017, 2019 онуудад 5 удаа шинэчилсэн. Газар зохион байгуулалт хөтөлбөрөөр магистрын сургалт явуулж эхэлснээс хойш 20 жилийн хугацаанд нийт 48 суралцагч магистрын зэргээ амжилттай хамгаалсан байна.

Анхаарах асуудал:

- ХААИС-ийн эрхэм зорилго, зорилтууд ГЗБ-ын магистрын хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг хэрхэн хангах тухай тусгадаг байх

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

1. Энэ хөтөлбөрөөр мэргэжлийн суурь 10 багц цаг, мэргэжүүлэх 12 багц цаг, судалгааны семинар 4 багц цаг, магистрын бүтээл 7 багц цаг нийт 33 багц цагийг судлах төлөвлөгөөтэй.
2. Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг
3. Хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд нь логик дэс дараалалтай, агуулгын хувьд давхардалгүй, суралцагч өдөр, эчнээгийн аль ч хувилбараар суралцах боломжтой, оюутан эхний улиралд 10 багц цаг, дараагийн улиралд 12 багц цагийг сонгож суралцах боломжтой байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантын лекц, семинар, лаборатори, дадлага, бие даан мэдээлэл цуглуулах, боловсруулах, судалгаа хийх, шалгалт гэх зэрэг суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай сургалтын цогц үйл ажиллагаа буюу ачааллыг нарийвчлан тооцож, ганцаарчилсан төлөвлөгөө санал болгодог.
- Магистрантын судалгааны арга зүйг хэлэлцэж баталдаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрөө сайжруулахад хэрхэн ашиглаж байгаа талаар оруулдаг байх хэрэгтэй.
- Лекцийн хичээлийн цаг 51,8 хувийг эзэлж байна. Магистрын түвшний сургалтын хувьд энэ нь оновчтой эсэхийг анхаарах

Зөвлөмж: Сургалтын төлөвлөгөөнд дэхь хичээлийг заавал болон сонгоны хичээлээр нь ялгаж тэмдэглэх.

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Илрэл нотолгоо:

1. Мэргэжлийн суурийн 4, мэргэшүүлэх 12 хичээлийн стандарт хөтөлбөртэй танилцсан.
2. Сүүлийн 5 жилд энэ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 2 удаа өөрчлөн шинэчилсэн. Хичээл тус бүрийн агуулгыг ГЗБ-ын магистр, докторын хөтөлбөрийн хороо, АЭС-ийн ЭЗ-ийн хурлаар тус тус хэлэлцэж баталдаг.
3. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 16 хичээлээс 4 хичээлийн нэр өөрчлөгдөж, 12 хичээлийн агуулгыг сайжруулсан. Үүнтэй холбогдуулан дадлагын хичээлийг лабораторийн хичээл болгож өөрчилсөн байна.
4. Хичээл тус бүр нь стандарт хөтөлбөртэй. Үүнд хичээлийн нэр, код, кредит болон түүний задаргаа, хичээлийн танилцуулга, хүрэх үр дүн, сэдэв-үр дүнгийн уялдаа, сургалтын арга зүй, оюутныг үнэлэх арга зүй, ашиглах сургалтын материалыг багтаасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- 12 хичээлийн агуулгыг шинэчилснээр гарсан үр дүн болон дадлагын хичээлийг лабораторийн хичээл болгож өөрчилснээр гарсан үр дүнг бичих.

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

1. ГЗБ хөтөлбөрийг Герман улсын Газрын менежмент ба газрын эрх зүй, Филиппин улсын Газрын удирдлаг менежмент, Танзани улсын Газар ашиглалтын төлөвлөлт менежмент, АНУ-ын Газар ашиглалтын төлөвлөлт хөтөлбөрүүдтэй харьцуулан судалгаа хийж, өөрийн онцлог тохируулан шинэчилсэн байна.
2. Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулгыг өөрийн онцлогт тохируулан тодорхойлсон.

Онцлог:

- Сургалтын хөтөлбөрийг АНУ, Герман, Филиппин, Танзани зэрэг 4 улсын 5 их сургуулийн магистрын хичээлтэй харьцуулахад 5-7 хичээл дүйцэж байгаа бөгөөд газар зохион байгуулалтын судалгааны аргазүй, газрын менежмент, төлөвлөлт, газрын эрхзүй, мэдээллийн систем, газрын эдийн засгийн чиглэлийн хичээлүүд давхцаж байна.
- Энэ хөтөлбөр нь Германы их сургуулийн хичээлтэй ойролцоо байгаа бол харин Филиппин улсынх нийгмийн чиглэлийн хичээлүүд давамгайлсан, Танзани улсынх байгаль орчин, АНУ-ын Невадагийн их сургуулийнх хотын газар, ландшафтын чиглэлийн хичээлүүд давамгайлсан байна.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрөөр магистрын сургалт явуулж байгаа МУИС-ийн ижил магистрын хөтөлбөртэй харьцуулахад 7 хичээл буюу нийт хичээлийн 54 хувь нь дүйцэж байна. Харин судалгааны аргазүй, байгалийн нөөцийн менежмент, газрын эрхзүйн болон ХАА-н газрын төлөвлөлт, мониторингийн чиглэлийн хичээлүүдээр ялгаатай байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал: Энэ шалгуурын хувьд өөрийн үнэлгээг хийхдээ “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрт тусгагдсан 16 хичээлийн зөвхөн нэрийг гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрийн хичээлийн нэртэй харьцуулсан нь учир дутагдалтай байна.

Шаардлага:

- Энд зөвхөн хичээлийн нэрээр харьцуулах биш, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон агуулгаар өөрөөр хэлбэл хөтөлбөрийг цогцоор нь гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулж улмаар “хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага” байх эсэхийг найивчлан судлах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

1. “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийн элсэлтийг жил бүрийн 4 болон 9 сард, жилд 2 удаа сургуулийн албан ёсны вэб сайт, олон нийтийн телевиз (Ийгл телевиз, TV10) болон facebook группээр зарлаж, нэгдсэн бүртгэлийн системээр бүртгэдэг. www.admission.muls.edu.mn
2. Магистрын хөтөлбөрийн элсэлтийг БШУС-ын 2014-09-12-ны А/370 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам” болон ХААИС-ийн захирлын 2014-11-14-ний А/377 тоот тушаал “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын дагуу зохион байгуулдаг бөгөөд эдгээр журмуудыг ХААИС-ийн Магистр МДС-ийн(https://graduate.muls.edu.mn/view_news.php?sub=20 (https://graduate.muls.edu.mn/view_news.php?sub=22) цахим хуудаснаас үзэх боломжтой.
3. Элсэхэд шаардагдах материалыг www.admission.muls.edu.mn болон оюутны ONEMIS цахим системд байршуулдаг.
4. “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-д зааснаар мэргэжлийн болон англи хэлний шалгалтад авбал зохих онооны 60-аас доошгүйг авсан тохиолдолд элсүүлдэг.
6. ХААИС-ийн магистр докторын гарын авлагыг 2003-2013 онд хэвлэмэлээр ашиглаж байгаад 2014 оноос МДС-ийн вэб хуудаст байршуулдаг болсон.
7. ХААИС нь өөрийн сургуулийн 3.2-оос дээш голчтой төгсөгчийг шалгалтгүйгээр магистрын хөтөлбөрт элсэх талаар журамласан байна.
8. Элсэн орсон магистрантын судалгааны сэдэв, удирдагч багшийг “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын 2.8.3, 2.8.4 заалт болон бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн ХААИС-ийн захирлын тушаалаар баталдаг. Удирдагч багшид тавигдах шаардлагыг БШУС-ын 2007 оны 187 тоот тушаалын 3 дугаар хавсралт “Магистрын зэрэг хамгаалуулах журам” -аар зохицуулдаг. /Суралцагч магистрантын магистрантын судалгааны сэдэв, удирдагч багшийг баталсан ХААИС-ийн захирлын тушаалууд/
9. Элсэн орсон магистрантын санхүүжилтийн хэлбэр хэмжээг БШУС-ын 2014-09-12-ны А/370 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, ХААИС-ийн захирлын 2014-11-14-ний А/377 тоот тушаал “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-аар зохицуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Газар зохион байгуулалтын магистрын хөтөлбөрийн элсэлтийг жилд 2 удаа нээлттэй зохион байгуулдаг.
- ХААИС нь өөрийн сургуулийн 3.2-оос дээш голчтой төгсөгчдийг шалгалтгүйгээр магистрын хөтөлбөрт элсэн орох урилга гардуулахаас гадна, төлбөрөө 15-30 хувийн хөнгөлөлттэй суралцах боломж олгодог. Мөн гадаад хэлний (TOFEL, IELTS) чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг магистрын хөтөлбөрийн элсэлтийн англи хэлний шалгалтын оноонд дүйцүүлэн тооцдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

1. МДС-ийн Захирлын 2019 оны 11-ний өдрийн А/294 тоот тушаалаар батлагдсан Газар зохион байгуулалт магистрын сургалтын төлөвлөгөө, “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын дагуу 33-аас доошгүй багц цаг судлах тухай оюутны ONEMIS цахим системээр мэдээлж, ажлын байрнаас нь холдуулахгүйгээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гарган МДС-ийн захирлын тушаалаар баталдаг.
2. Магистрын хичээлийн хуваарийг улиралд 10-12 багц цаг байхаар тооцож, “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийн хорооны зохицуулагч хичээлийн хуваарь хийдэг. Энэ талаар магистрант, төгсөгчидтэй уулзалт хийх үед асуухад нотолж байсан.
3. Мэргэжлийн суурь хичээлүүд нь нийт 10 багц цаг байх бөгөөд мэргэжлийн суурь хичээлийн хуваарийг МДС-ийн захирал батлан нэгдсэн журмаар цахим хуудаснаа байршуулж, магистрант тус бүрт мэдээлэл хүргэдэг.
4. Сургалтын төлөвлөгөөн дэх заавал үзэх 10 багц цагийг судалсны дараа удирдагч багшийн тусламжтай судалгааны арга зүйгээ бичиж, харъяа тэнхимийн хурлаар хэлэлцүүлж батлуулдаг. Үүнийг Газар зохион байгуулалтын профессорын багийн судалгааны семинарын хуваарь, тэнхимийн хурлын шийдвэрт тусгасан байв.
5. Мэргэшүүлэх хичээл нийт 12 багц цаг байх бөгөөд хөтөлбөрийн хорооны зохицуулагч тухайн улиралд суралцаж байгаа магистрантуудын ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу хичээлийн хуваарь гарган сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хөтөлбөрийн ахлагчаар хянуулан МДС-ийн захирал баталгаажуулдаг.
6. Магистрант өөрийн судалгааны сэдвийн хүрээнд онолын болон судалгааны арга зүй эзэмших зорилгоор сонгон судлах хичээлийг удирдагч багштай хамтран ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу судалдаг. Энэ нь ONEMIS цахим систем, МДС-ийн захирлын тушаалаар баталсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, суралцагч магистрантын магистрантын судалгааны сэдэв, удирдагч багшийг баталсан ХААИС-ийн захирлын тушаал, Газар зохион байгуулалтын профессорын багийн судалгааны семинарын хуваариар нотлогдож байна.
7. Судалгааны 4 багц цагийг судагааны семинарт 2-оос доошгүй удаа судалгааны үр дүнгээ хэлэлцүүлж тооцуулдаг.
8. БШУС-ын 2014-09-12-ны А/370 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, ХААИС-ийн захирлын 2014-11-14-ний А/377 тоот тушаал “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”, МДС-ийн захирлын тушаалаар баталсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу магистрын төгсөлтийн ажлыг 7 багц цагаар дүүргэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд судлах мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүд нь улирал бүрт жигд байгаа боловч судалгааны арга зүйгээ батлуулах, судалгаа хийх, цаашилбал магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг эсэх нь шууд нотлогдоогүй.

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

4. 2017 оноос эхлэн асуудалд суурилсан туршилтанд суурилсан, түүхт суурилсан, нөхцөлд суурилсан, тоглоом ба симуляци, төсөлд суурилсан арга зүйг ашиглан, багаар ажиллах ур чадвар, судлаачийн ёс зүйг эзэмшүүлж байгаа нь МДС-ийн захирлын тушаалаар баталсан Газар зохион байгуулалтын магисрын хөтөлбөрийн хичээлийн стандарт хөтөлбөр, Газар зохион байгуулалтын профессорын багийн багш нарын боловсруулсан хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөгөөр нотлогдож байна.
5. Магистрын хөтөлбөрийн сургалтаар ГЗБГЗЗГ, нийслэлийн ГЗБА, аймгуудын ГХБХБГ болон орон нутгийн газрын алба, сургалт эрдэм шинжилгээний хүрээлэн, мэргэжлийн байгууллагууд, газар зохион байгуулалт, газрын кадастр, геодезийн компани болон бусад салбарт хөрвөн ажиллах ур чадварыг эзэмшүүлж байна. Энэ нь байгууллагуудтай хамтран хийсэн судалгааны төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, газарзүйн мэдээллийн системийн лицензтэй программ болон газрын харилцааны салбарт ашиглагддаг программ хангамж, Газар ашиглалт, төлөвлөлтийн лаборатори, Бэлчээрийн газрын судалгааны лаборатори, Газрын кадастрын лаборатори, Геомэдээллийн лаборатори болон Газрын үнэлгээ мониторингийн лаборатори болон магистрант оюутнуудын бүтээлүүдээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Газар зохион байгуулалтын магистрын хөтөлбөрийн сургалтын орчинг сайн бүрдүүлсэн, сургалт нь Газар ашиглалт, төлөвлөлтийн лаборатори, Бэлчээрийн газрын судалгааны лаборатори, Газрын кадастрын лаборатори, Геомэдээллийн лаборатори болон Газрын үнэлгээ мониторингийн лаборатори зэрэг газарзүйн мэдээллийн системийн лицензтэй программ болон газрын харилцааны салбарт ашиглагддаг программ хангамжуудаар хангагдсан лабораториудад түшиглэн явагдаж байна. Энэ нь магистрын хөтөлбөрт хичээл зааж буй багш нар болон магистрант оюутнууд газар ашиглалт, төлөвлөлт, орон зайн дүн шинжилгээ, газрын тохиромжтой байдлын үнэлгээ, газрын эрхийн бүртгэл зэрэг газар зохион байгуулалтын бүхий л салбарын практик үйл ажиллагаа, шаардлагатай программ хангамжуудыг ашиглах талаар нэг талаас багшлах арга зүй болон нөгөө талаас суралцах арга зүйг суралцагч төвтэй арга барилд тулгуурлан явуулах боломжийг бүрэн олгож байна.
- COVID-19 цар тахлын улмаас ХААИС-иас өөрийн сургуулийн нийт багш нарт онлайн хичээл хөтлөн явуулах, багшийн заах арга зүй болон онлайн хичээлийн агуулгыг сайжруулах чиглэлээр сургалтыг зохион байгуулсан нь цаашид

магистрын хөтөлбөрийн хичээлүүдийг цахимаар зохион байгуулах, хөдөө орон нутгийн магистрант оюутнуудыг хичээлд идэвхитэй хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болсон байна.

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын төлөвлөгөөн дэх заавал үзэх 10 цагц цагийг судлах явцдаа судалгааны чиглэл сэдвээ тодорхойлдог. МДС-ийн веб хуудсанд агро-экологи, байгаль шинжлэл болон газрын харилцааны хөтөлбөрөөр элсэгчдэд зориулсан судалгааны 63 чиглэл байгаагийн 27 нь газар зохион байгуулалтын судалгааны чиглэл байна.
2. Магистрант элсэж орохдоо өөрийн судалгааны сэдэв, удирдагчаа сонгох эрх нь нээлттэй байдаг.
3. “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийн хорооны зохицуулагчийн 2016-2020 онд гаргасан бүртгэл судалгаанаас харахад 9 магистрант судалгааны арга зүйгээ батлуулсан нь элсэгчдийн 25.1%, 8 магистрант судалгааны ажлаа хамгаалсан.
4. 2016-2020 онд Агроэкологийн сургуулийн магистр, докторын эрдэм шинжилгээний хурлыг 4 удаа зохион байгуулсан бөгөөд ГЗБ-ын магистрын хөтөлбөрийн 6 магистрант оролцсныг эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр, эмхтгэлд тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016-2018 онд элссэн 12 оюутанд Инбаунд менежмент хийж, удирдагчийг тодорхойлж, судалгааны ажлыг эхлүүлэх шаадлагатайг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн элсэгчдэд зориулан удирдагч багш нарын судалгааны чиглэлийг нээлттэй танилцуулж, судалгааны сэдэв санал болгодог.
- ХААИС-д магистр докторын судалгааны ажлыг дэмжих зорилгоор шилдэг судалгааны ажил шалгаруулдаг.

Анхаарах асуудал:

- Элсэж орсон оюутнуудын тоотой судалгааны арга зүйгээ батлуулсан оюутныг харьцуулахад буюу заавал үзэх 10 багц цагаа судалсны дараа магистрын судалгааны ажлын сэдэв болон удирдагчаа батлуулж, судалгааны ажлаа эхлүүлсэн оюутан цөөн байна.

Зөвлөмж:

- Магистрант оюутны судалгааны ажлыг идэвхижүүлэх, магистрын суралцах хугацаанд хязгаар тавих, салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх грант төслүүдийг хэрэгжүүлэх, түүнд магистрант оюутнуудыг хамруулах зэргээр асуудлыг шийдэх боломжийг судлах нь зүйтэй.

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

1. Агроэкологийн сургуулийн магистр, докторын эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр, эмхтгэл, төсөл хөтөлбөр, судалгааны ажил, захиалгат болон гэрээт ажлуудын тайлан.
2. Газрын менежментийн тэнхим 2016-2020 онд Олон улсын хэмжээний 2 хурал, “Газрын харилцаа” 2016-2020 оны хурлуудыг БХБЯ, ГЗБГЗЗГ, ГГЭХ, МГЗБХ-той хамтран зохион байгуулсан бөгөөд МУИС, ШУТИС, Дарханы салбар ХААИС, МҮИС болон ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаатай их дээд сургуулиудын судлаачид, оюутнуудыг оролцуулж, бүтээлийг нь эмхтгэл болгон олны хүртээл болгож байна.
3. Магистрантууд удирдагч багшийнхаа хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, судалгааны ажил, захиалгат болон гэрээт ажлуудад оролцож, судалгааны ажил хийн, үр дүнгээ тайлагнадаг.
- 4.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг

Илрэл нотолгоо:

- МДС-ийн захирлын тушаалаар баталсан Газар зохион байгуулалтын магисрын хөтөлбөрийн хичээлийн стандарт хөтөлбөр, Газар зохион байгуулалтын профессорын багийн боловсруулсан хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө зэрэг нь шаардлагын дагуу боловсруулагдсан
- ХААИС-ийн захирлын 2012-10-25-ны А/314 тоот тушаал “ХААИС-ийн оюутны мэдлэг чадварыг үнэлэх журам”-тай
- Оюутны ONEMIS цахим системтэй
- Стандарт (A, B, C, D, F) болон стандарт бус (CR, NC, E, W, R) үнэлгээг ашигладаг. Улирлын турш оюутны мэдлэгийг 70 хүртэл оноогоор дүгнэнэ. Үүнээс ирц 10, онолын мэдлэг даалгаврын биелэлт 40, бие даалт 20 оноо байна. 70 онооны 30-аас дээш хувийн үнэлгээ авсан оюутан улирлын буюу хөндлөнгийн шалгалтанд орно.

- Хичээлээр эзэмших мэдлэг, мэдлэгийн ур чадвар, хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэхдээ сургалтын заах арга зүйтэйгээ уялдуулан ихэвчлэн рубрикийн, хээрийн хэмжилт судалгаа, харьцуулалт хийх, тайлан тавих зэрэг аргыг хэрэглэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн захирлын 2014-11-14-ний А/377 тоот тушаал “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын дагуу өөр хөтөлбөрөөр төгсөгч ГЗБ-ын магистрын хөтөлбөрт суралцах тохиолдолд сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдийн өмнөх холбоонд тусгагдсан зөрүү хичээлийг заавал судалдаг.
- МДС-ийн захирлын тушаалаар баталсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй
- “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийн хорооны зохицуулагчийн гаргасан хичээлийн хуваарь гарсан
- Бусад сургуульд сурсан хичээлийн дүйцүүлэлтийг магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журмын 2.3.5 дугаар заалтаар зохицуулна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрантын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж, баримтжуулан, шийдвэрлэдэг. Өнөөгийн байдлаар нэг магистрант оюутан гомдол гаргасан бөгөөд асуудлыг “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийн хорооны зохицуулагчийн тусламжтайгаар шийдвэрлэсэн. Өөр санал, хүсэлт, гомдол бүртгэгдээгүй.
- Шинээр элссэн магистрантуудыг хөтөлбөрийн зохицуулагч бүртгэн авч, сонирхож буй судалгааны чиглэлийг нь харгалзан хичээл сонголт хийх, ганцаарчилсан төлөвлөгөө гаргахад нь дэмжлэг үзүүлдэг.
- Магистр, докторантын гарын авлагыг хэвлэмэл байдлаар тараахаас гадна цахим хэлбэрээр сургуулийн вэб сайтад шинэчлэгдэн ордог.
- Сургууль дээр ажиллах хугацаанд хэвлэмэл гарын авлагатай танилцсан, цахим гарын авлагыг https://graduate.muls.edu.mn/view_news_haais.php?id=99

- Суралцагчийн судалгаа шинжилгээний ажлыг дэмжих үүднээс жил бүр магистр, докторын оюутнуудын дунд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, шилдэг оюутан, судалгааг шалгаруулан 1-2 сая төгрөгийн шагнал олгодог.
- ХААИС-ийн захирлын 2016 оны тушаалаар баталсан “Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам” https://graduate.muls.edu.mn/view_news.php?sub=24

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн магистрант оюутан ямар нэг судалгааны санхүүжилт авах шууд заалт байхгүй ч шилдэг эрдэм шинжилгээний бүтээлд шагнал олгох талаар ХААИС-ийн захирлын 2016 оны А/45 тоот тушаал “Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл олгох журам” байдаг.
- ГЗБ-ын магистрын хөтөлбөрийн магистрантуудаас шилдэг бүтээлийн грант, шагнал авч байгаагүйг багш нар ярилцлагын үед дурьдсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлбөрийн тодорхой хувийг судалгааны ажилд зарцуулж байх, судалгааны ажлын санхүүжилтийг боловсронгуй болгох талаар МДС-ийн сургууль санал аван, журмын төсөл боловсруулж байна.
- Газар зохион байгуулалтын профессорын баг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, захилгат болон гэрээт ажилд магистрант оюутнуудыг татан оролцуулж хээрийн судалгаа хийх, судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлэх зэргээр удирдаж буй магистрант оюутнуудын судалгааны ажилд дэмжлэг үзүүлдэг. Гэсэн хэдий ч энэ нь багшийн ажлын үнэлгээнд тусгагддаггүй, үнэлэгддэггүй учраас анхаарлын гадна орхигддог.

Шаардлага:

- ГЗБ-ын магистрын хөтөлбөрийн хувьд сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг судлах
- Магистрант оюутныг удирдагч багш өөрийн удирдаж, оролцож буй олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний судалгааны төсөл, захилгат болон гэрээт ажилд татан оролцуулж хээрийн судалгаа хийх, судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлэхэд үзүүлсэн дэмжлэгийг профессор багшийн хөгжил, чадамжийн түвшинг үнэлэх шалгуурт оруулснаар багш болон магистрант оюутнуудын судалгааны ажлын идэвхижүүлэх, судалгааны санхүүжилийг шийдвэрлэдэг туршлагыг судлан хэрэгжүүлэх

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь өөрийн сургуулийн 3.2-аас дээш голч дүнтэй төгсөгчиддөө магистрын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсэн орох урилга гардуулахын зэрэгцээ төлбөрийн 15-30 хувийн хөнгөлттэй суралцах боломж олгодог.
- ХААИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу өөрсдийн ажилтан албан хаагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- ГЗБ-ын профессорын баг нь гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран Улсын болон аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачлал, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, Газарзүйн нэрийн ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, Газрын засаглалын үнэлгээний ажил, Газрын салбарын хамтын ажиллагааны стратеги хэрэгжүүлэх ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд магистрант оюутнуудаа амжилттай хамруулсан.
- ГЗБ-ын профессорын баг нь Монголын Газар зохион байгуулагчдын холбоотой хамтран “Газар зохион байгуулалт, газрын кадастрын хүрээний мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэг олгох, горилох сургалт”-уудыг жилд 2 удаа тогтмол явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монголын Газар зохион байгуулагчдын холбоотой хамтран “Газар зохион байгуулалт, газрын кадастрын хүрээний мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэг олгох, горилох сургалт”-ыг зохион байгуулдаг туршлагатай ганц профессорын баг.

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

1. ХААИС-ийн захирлын 2015 оны 3 дугаар сарын 24-ний А/73 тоот тушаал, 2019 оны 12 дугаар сарын 27-ны А/335 тоот тушаалаар баталгаажуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй “Магистрын ажил хамгаалуулах зөвлөл”-өөр магистрын судалгааны ажлыг хэлэлцүүлэн хамгаалдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.8 Төгсөлтийн баримт бичиг Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

1. 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот тушаал “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэн гаргасан МДС-ийн дотоод журмын дагуу төгсөлтийн материалыг бүрдүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалт, БШУ-ны сайдын 2014 оны 09 сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалыг үндэслэн профессор багш нарыг ажиллуулдаг.
2. ГЗБ-ын магистрын хөтөлбөрт хичээл заадаг 27 багш 100 % докторын зэрэгтэй байгаа нь өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлагатай багш, судлаачийн нөөцтэй байгааг нотолж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ГЗБ хөтөлбөрийн хорооноос салбартаа тэргүүлэгч, мэрэгжлээрээ 10-аас дээш жил ажилласан, доктороос дээш зэрэгтэй багшийн судалгааг гаргасан бөгөөд судалгаанаас үзвэл 27 багш байгаагаас тэнхимийн үндсэн 7 багш, ХААИС ийн харъяа сургуулийн 13 багш, төрийн байгууллага болон мэргэжлийн холбоо бусад сургуулийн 7 багш байна.
- “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийг улсын хэмжээнд анх удаа батлуулан мөрдөж ажиллаж байгаа бөгөөд тус төлөвлөгөөнд тусгасны дагуу багш нарыг хөгжүүлэх чиглэлээр тогтмол сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.
- ГЗБ –ын магистрын хөтөлбөрт нийт 14 багш 24 магистрантад хичээл зааж байгаа бөгөөд 1 багшид 2 магистрант ноогдож байна.
- СБЗА -нь 2018 онд “Багшийн хөгжил хөтөлбөр”- ийн хүрээнд профессор багшийн суурь чадамжийн үнэлгээг үндсэн 4 чадамж, 30 дэд чадварын үзүүлэлтээр бүх багшийг үнэлсэн ба тухайн багш нь ямар чадвар,доогуур үнэлгээтэй байгааг харгалзан холбогдох сургалтуудад сууж чадамжийн хүрээгээ жил бүр нэмэгдүүлж байна

Зөвлөмж:

- Олон улсын тэргүүлэх судлаач,эрдэмтдийг урьж ажиллуулах

4.2 Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

1. Багшийн ажлыг өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээгээр хийдэг.Эхнийх нь багш өөрийн үнэлгээний тайлангаа бичиж тэнхимийн хурлаар хэлэлцүүлэх үе шатаар хийгддэг.
2. Багш нар өөрийн хүсэлтийн дагуу аттестатчилалд ордог бөгөөд энэ хөтөлбөрийн багш Уранбилэг, Мягмаржав нар 2019 оны аттестатчиллд амжилттай оролцож албан тушаалын зэрэглэлээ ахиулсан.
3. Төгсөгчдөөс багш нарыг 2 ур чадварыг үнэлэх 8 асуумжаар тодорхойлсон сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр төгсөгчид багш нарын заах арга зүй, ур чадварыг 3.92-4.42 хооронд буюу сайн гэж үнэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан хөтөлбөрийн зорилго зорилтуудад нийцүүлэн багшийн ур

чадварыг шударга, бодитой, системтэй тогтмол үнэлж үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг.

- Багш нар жил бүр тайлан бичиж өөрийн үнэлгээ хийх ба дараа жил өөрийгөө хөгжүүлэх зорилгоо тодорхойлж хамт олныхоо саналыг авдаг. Багш нарын өөрийн үнэлгээний тайланг хэлэлцсэний дараа бүрэлдүүн сургуулийн удирдлагууд болон хөтөлбөрийн хорооны ахлагч, зохицуулагч нар нотлох баримтуудтай танилцан хөндлөнгийн үнэлгээ өгч зөвөлгөө өгдөг. Мөн тэнхимийн зүгээс багш нарын ажлын үр дүнг оноогоор илэрхийлж хооронд нь харьцуулж зөвлөн туслах үйл ажиллагаа явуулдаг байна.
- Багшийн ажилд ХААИС- ийн удирдлага, сургалтын алба, магистр, докторын сургууль, магистрын хорооны зохицуулагч, эрдэмтэн нарийн бичиг, профессор багш аттестачлах комиссын гишүүд хөндлөнгийн хяналт тавьдаг.
- Хөндлөнгийн хяналтыг Гадаадын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, Профессор багшийн аттестатчлал, Сургалтад оролцогчоор багшийг үнэлүүлэх гэсэн олон төрлийн арга хэлбэрээр хийдэг.
- Магистрын хөтөлбөрт суралцагсдаас багшийн сургалтын ур чадвар, заах арга зүй, ёс зүйн талаар сэтгэл ханамжийн судалгааг 2017 оноос авч эхэлсэн. Энэхүү судалгаагаар суралцагсдын ерөнхий сэтгэл ханамжийг судлахаас гадна цаашид анхаарах асуудлыг тодруулдаг.

Анхаарах асуудал:

- Төсөл судалгаандаа магистрантуудыг оролцуулж тодорхой дэмжлэг үзүүлж байгаа багш нарын ажлын үнэлгээг бодитой тооцдог болох.

4.3 Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС- ийн захирлын 2002 оны 11-р сарын 20 – ний өдрийн 156 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулсан.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс ХААИС-нь 2017-2018 оны хичээлийн жилд шинээр багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу LCE програм хангамжийг шинээр нэвтрүүлж, “Багшийн хөгжил төв” байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй,

инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг.

- ХААИС- ийн ректорын 2002 оны 11-р сарын 20 – ний өдрийн 156 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 11 модулаас бүрдсэн LCE програм хангамжийг нэвтрүүлсэн.
- Багш судлаачдыг бэлтгэх, чадавхийг нь бэхжүүлэхээр “Багшийн хөгжил төв” байгуулсан.
- Судалгааны бүтээлийн тоо, чанарт ахиц гаргахын тулд багш нар бүтээлээ хэвлүүлсэн байдлыг үндэслэн урамшуулж шагнах, ХАА сэтгүүл, АГРОЭКОЛОГИ сэтгүүл болон бусад үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх ISBN дугаартай сэтгүүлд англи болон монголоор өгүүлэл хэвлүүлсэн, иш татсан байдлыг харгалзан урамшуулал олгодог болсон нь хэвлэн нийтлүүлэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн.
- 2016 онд ном сурах бичиг гаргаагүй монограф гарын авлага 2-ыг хэвлүүлж байсан бол 2020 онд 2 сурах бичиг гаргаж 2 монограф, 3 гарын авлага гаргаж гадаад дотоодын хэвлэлд нийтлүүлсэн мөн ЭШ-ний бүтээлийн тоо өссөн байна.
- ХААИС-ийн УЗ-ийн 2010 оны 7 сарын 05 ны хурлаар ойрын 10 жилд хөгжлийн шинэ шатанд гаргах иж бүрэн баримт бичиг болох “ХААН КАМПУС” хөтөлбөр баталж хэрэгжүүлж байна

Зөвлөмж:

- Судалгаа үйлдвэрлэлийн институтийг түшиглэн магистрын судалгааны ажлыг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх

4.4 Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар 2017-2020 онд 119 эрдэм шинжилгээ өгүүлэл хэвлүүлж, 106 төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн.
2. Улсын захиалгат болон гэрээт ажил, инновацийн суурь судалгааны төслийн хэрэгжүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.
3. Судалгаа шинжилгээний ажилдаа магистрантуудыг татан оролцуулж байна.
- 4.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажилд магистрант докторантуудыг оролцуулдаг.
- Тэнхимийн багш нар салбарын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын хэмжээнд болон дотоодын төсөл, захиалгат болон гэрээт ажил инновацийн суурь судалгааны төсөл боловсруулан гүйцэтгэж өөрсдийн судалгаа шинжилгээний ажлын ур чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ сургууль, сургалтын бааздаа хөрөнгө оруулалт хийх, судалгааны арга зүйгээ шинэчлэх, олон улсын түвшинд хамтран ажиллах зэргээр мэрэгжлийн ур чадвараа дээшлүүлсээр байна.
- Япон улсын олон улсын судалгааны төв (JIRCAS) болон “Зүүн хойд азийн бэлчээрийн эрсдлээс урьдчилан сэргийлэх төсөлд магистр докторантуудыг судлаачаар оролцуулсан.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1 Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

1. Тус сургууль нь 66 анги танхим, 6 лаборатори ашиглан сургалт явуулдаг бөгөөд утасгүй интернетээр холбогдсон, лекцийн танхим, дадлагын танхимд телевиз байрлуулан видео хичээл явуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. Геомэдээллийн, Газрын кадастрын, Газар ашиглалтын, Газрын үнэлгээ мониторингийн лабораториудыг шинэчлэн сургалт-судалгааны ажилд ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Геомэдээллийн лабораторит Газар зүйн мэлээлэл тандан судалгаа, Газрын кадастрын лабораторит Кадастрын судалгаа, газрын бүртгэл, Газар ашиглалтын лабораторит Газар ашиглалт газар зохион байгуулалтын төлөвлөлт, хот төлөвлөлт, Газрын үнэлгээ мониторингийн лабораторит газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээ газар, хүрээлэн буй орчны мониторингийн чиглэлээр тус тус сургалт судалгаа явуулж байна.
- Газар зохион байгуулалтын магистрын хичээл зааж буй багш нарт ногдож байгаа өрөө тасалгааны хангамж 2016 онд 1 хүнд 7.5м.кв 1 магистрантад ногдох

хичээлийн танхим 5.4м.кв байсан бол 2020 онд 1 багшид 36.4м.кв,1 магистрантад 9.9м.кв болж нэмэгджээ.

- Тус сургуулийн багш нар компьютер болон бусад дагалдах хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд магистрантууд болон оюутны Онлайн сургалтын таатай нөхцлийг хангах зорилгоор GOOGLE CLASSROOM платформыг ашиглахын зэрэгцээ лабораторуудын хүчин чадлыг байнга шинэчлэн сайжруулж байна.
- Агроэкологийн сургуулиас санхүүжүүлэн лекцийн 2 танхимыг орчин үеийн тоног хэрэгслээр хангаж ухаалаг интерактив компьютер суурилуулсан ба “Оюутны хөгжил” хөтөлбөрийн хүрээнд оюутны танхимыг тохижуулсан байна.

5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Газар зохион байгуулалын хөтөлбөрөөр суралцагсад ХААИС-ийн төв болон МЭС, ЭЗБС- ийн номын сан, Газрын менежментийн тэнхимийн ном, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний тайлан болон бусад бүтээлүүдээр үнэ төлбөргүй үйлчлүүлдэг.
- Цахим номын сан хөтөлбөрийн хүрээнд 2017 оноос хойш Lib4U Net Version програмын шинэчилсэн хувилбарыг ашиглаж байна.
- Магистр докторын сургуулийн өөрийн <https://graduate.muls.edu.mn/> сайтыг ХААИС-ийн номын сангийн сайттай холбосон бөгөөд энэ холбоосоор монгол улсын ШУ академи, хүрээлэн их дээд сургууль, коллеж, аймаг сумдын 84 цахим номын сан болон гадаадын номын сангуудтай танилцах боломжийг олгож байна.
- ХААИС –ийн номын сан 2020 оны эцсийн байдлаар 44122 нэр төрлийн 170485 ном сурах бичигтэй бөгөөд үүний 829 нь тоон хэлбэрт орсон байна.
- ХААИС-ийн бүрэлдүүн сургуулиуд өөрийн онцлогийг харуулсан номын сантай бөгөөд ГЗБ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим өөрийн номын фондтой болсон байна.
- Тухайн шинжлэх ухааны талаар ховордсон номуудыг Улсын төв номын сан болон гадаад дотоодын бусад их дээд сургуулиуд бие даасан номын сангуудтай солилцоо хийж авдаг байна.
- Номын сангийн эрдэм шинжилгээний фондын бүрдэлтийг ХАА-н эрдэм шинжилгээний бүтээлүүд болон шинжлэх ухааны танин мэдэхүйн сэтгүүл, Ботаникийн хүрээлэн, Агроэкологи сэтгүүл, Газрын харилцаа сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлуудын эмхэтгэл зэргээр баяжуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ГЗБ магистрын хөтөлбөрт цахим эх үүсвэрийн мэдээлэл төрөлжсөн програм хангамжуудыг ихээр ашигладаг бөгөөд энэ нь тухайн магистрын хичээлээр олж авах мэдлэг чадварыг дээшлүүлэх, цаг хэмнэх, мэдээтэй ажиллаж сурах чадварыг дээшлүүлэх, судалгааны ажлыг гүйцэтгэхэд чухал эх үүсвэр болдог. Тухайлбал Газар зүйн мэдээллийн E-gazar.mn, ArcGIS pro, ArcGIS, Бэлчээрийн ургамлын мониторингийн Sample Point Газрын бүртгэлийн Ланд менежер, Газар ашиглалт хот төлөвлөлтийн AutoCAD програмуудыг ашиглаж байна.

5.3 Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

Илрэл нотолгоо:

- Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн 1 кредитийн үнэлгээ 2016 онд 87100 төг байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд ХААИС-ийн захирлын тушаалаар 10000 төгрөг болж өссөн байна. 2016-2020 онд дунджаар 623410 мян.төгрөгийн орлоготой ба санхүүгийн хувьд ашигтай ажилласан байна. Тус сургууль нь сургалттай холбоотой шууд ба шууд бус зардалд жилд дунджаар 281,2 мянган төгрөгийг зарцуулж байна.
- ХААИС-ийн 2020 онд элссэн нийт магистрын тоо 2 дахин ихссэн боловч Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн нийт суралцагсдын тоо буурсан байна.
- ХААИС –ийн магистрын хөтөлбөрөөс 88,920 мян.төг орж байгаа нь нийт орлогын 14.2 хувь болж байна.ХААИС-ийн санхүүгийн тайлангаас харахад нийт магистрын сургалтын сургалттай холбоотой шууд зардалд 2016 онд нийт орлогын 90 хувь, 2020 онд 76.4 хувь зарцуулсан бол шууд бус зардалд 2016 онд 1.5 хувь 2020 онд 2.2 хувийг зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ХААИС-ийн төсвийн төлөвлөлтөнд магистрын судалгааны ажил,грантыг буй болгох журам, дүрмийг боловсруулах судалгааны сургууль болох магистрын судалгааг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн ажиллах хэрэгтэй байна.
- Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх журмыг хэрэгжүүлэх.
- Лицензтэй програмын төлбөрийг их сургуулийн төсөвт тусгадаг байх

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

6.1 Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- 2014 оноос ХААИС Хөтөлбөрийн Хороод байгуулагдаж, хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж эхэлсэн.
- 1. МДС нь ХЕХ, ХДХ, МХХ-гоор хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, сайжруулахтай холбоотой ажлыг үе шаттай хэлэлцэн баталгаажуулдаг. Мэргэжлийн хөтөлбөрийн хороог 2014 байгуулснаас хойш бүрэлдэхүүнийг нь 2015, 2017, 2019 онуудад өөрчилж ажилласан. Магистр, докторын сургалтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталдаг. Энэ хөтөлбөрийн хороо нь ахлагч, зохицуулагч, дотоод хяналтын гишүүн, хөндлөнгийн хяналтын гишүүн болон бусад гишүүдээс бүрддэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хөтөлбөрийн хорооны зохицуулагчид багц цагийн хөнгөлөлт олгогддог. МХХ-ны зохицуулагчыг профессор багш нараар ээлжлэн хийлгэж оролцоог тэгш хүртээмжтэй хангадаг.

Анхаарах асуудал:

- Захиргааны бүтцийг магистрын сургалт нь бакалаврын сургалттайгаа уялдаа холбоотой байхаар зохион байгуулах.
- Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд дэмжих үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх

Зөвлөмж:

- ГЗБ хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц, үйл ажиллагаа, бүрэлдэхүүний ажлын үр чадвар болон академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагын талаар дэлгэрэнгүй оруулах.

6.2 Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих үр чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

2. Магистрын сургалтыг МДС удирдлагаар ханган ажилладаг. Захирал, хөтөлбөрийн эрхлэгч, 2 мэргэжилтэн ажилладаг.
3. Харин их сургуулийн хэмжээнд 22 номын санчийн мэдлэг, үр чадварыг тогтмол дээшлүүлж ирсэн бөгөөд 50 % нь магистрын зэрэгтэй болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь хэрхэн дэмжлэг үзүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Шаардлага :

- Энэ шалгууртай холбоотой “Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлсэн” талаар нотлох баримт оруулах.

6.3 Удирдлагын мэдээллийн систем

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

1. ХААИС нь магистрын түвшний сургалтандаа Бидсольюшин ХХК-ны OneMIS v2.0 удирдлагын мэдээллийн системийг ашиглахаар болж, эхлэл ажлуудыг хийж эхлээд байна. OneMIS систем нь уян хатан шийдлүүдийг агуулсан нэгдмэл систем бөгөөд хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн, хурдтайгаа хувьсан өөрчлөгдөж, өсөн нэмэгдэж байгаа энэхүү мэдээллийн зуунд их дээд сургуулиудын мэдээллийн урсгалыг зөв удирдаж, өдөр тутам үйл ажиллагаанд хэрэглэгдэх систем болсон.
2. ХААИС нь [muls.u.mn](https://graduate.muls.edu.mn/view_news.php?sub=23) цахим хуудсыг тогтмол ажиллуулдаг бөгөөд МДС нь https://graduate.muls.edu.mn/view_news.php?sub=23 цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ахисан түвшний хөтөлбөр, түүнтэй холбоотой дүрэм журмыг хүргэдэг.

Онцлог:

- ХААИС-ийн вэб хуудсаар дамжуулан боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхээс өмнө суралцагч болон олон нийтэд мэдээллээ хүргэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

Анхаарах асуудал:

- ХААИС-ийн хувьд Удирдлагын мэдээллийн системийг бакалаврын болон ахисан түвшинд тус тусад нь ашиглаж байгаа нь сургалтын үйл ажиллагааг шуурхай, оновчтой, харилцан уялдаатай удирдан зохион байгуулахад хүндрэлтэй.
- Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн бүртгэл мэдээллийн өгөгдлийг нэмэгдүүлэх, түүнийг боловсруулж хөтөлбөрөө сайжруулахад хэрэглэсэн нотолгоо байхгүй.

- 45-48 дугаар зургийн доторх цонхны нэрс уншигдахгүй байна.

Шаардлага:

- УМС-ээс гарч байгаа бүх мэдээллийн жагсаалтыг оруулах.
- Их сургуулийн хэмжээнд нэдсэн нэг УМС хэрэглэж, тасралтгүй хөгжүүлэх
- 45-48 дугаар зургийн дотор байгаа цонхны нэрсийг тодруулах.

6.4 Мэдээллийн ил тод байдал

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Магистрант УМС-ээс суралцагчдад тавигдах шаардлага, сургалтын төлөвлөгөө, гарын авлага, дүнгийн мэдээлэл, хичээл сонголтын мэдээлэл, хичээлийн хуваарь, анкет, судалгааны семинарын хугацаа, ЭШХ-ын тов зэрэг мэдээллийг авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Мэдээллийг хэн, хэзээ, хэрхэн шинэчлэх, оруулах талаар заавар, зохицуулалтгүй.
- ӨҮТ-д хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж байгаа нотолгоо болон мэдээллийг тогтмол шинэчилдэг талаар оруулаагүй байна.

Шаардлага:

- Мэдээллийг ил тод байлгах түүний аюулгүй байдлыг хангах тухай заавар, журам боловсруулж мөрдөх.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1 Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС –д “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд 2018 онд Чанарын удирдлага, зохицуулалтын алба байгуулагдан хүний нөөц, хяналт, шалгалт, үнэлгээ болон чанарын баталгаажуулалт гэсэн 3 үндсэн чиглэлээр ажиллаж байна.
- 2020 онд СБЗА аас гаргасан “Хөтөлбөрийн чанарын менежментийн гарын авлага”-г баримтлан ажиллахаар болсон.
- 2018 онд “Газар зохион байгуулалт хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2017-2024” боловсруулж мөрдөж байна. Хөтөлбөрийн стратегид тусгагдсан хөтөлбөрийн сайжруулалт, чанарын баталгаажуулалттай холбоотой 9 заалтаар дүгнэж үзэхэд гүйцэтгэл дунджаар 51.1%-тай байна.
- 2018 оноос хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2 жил тутамд олон улсын чанарын менежментийн тогтолцооны PDCA зарчмаар төлөвлөж хөтөлбөрийн хороон ахлагч батлан, хэрэгжүүлж байна.
- ХААИС-ийн чанарын баталгаажуулалтын удирдлага, зохион байнуулалтын схемийн дагуу магистрын хөтөлбөрт суралцагсад болон төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгаа, хөтөлбөрийг гадаадын ижил төстэй хөтөлбөрүүдтэй

харьцуулан сайжруулах судалгаанууд, ахисан түвшний сургалтын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудыг татан оролцуулах ажлыг хийж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

Анхаарах асуудал:

- Чанарын удирдлага, зохицуулалтын алба нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийдэггүй.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажилтын нэгдсэн тогтолцоо сул байгаагаас хөтөлбөрийн стратегийн төлөвлөлт хийгдэж байгаа боловч тэнхим, нэгждээ хийсэн ажлын хэрэгжилтийн үр дүн төдийлэн сайнгүй байна.

Зөвлөмж:

- “ХААИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажилтын журам” боловсруулж мөрдөх.
- Чанарын удирдлага, зохицуулалтын алба нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтад чиглэсэн бодитой ажил хийх
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг Агроэкологийн Сургуулийн болон тэнхимийн жил жилийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг үнэлж, хянах нь зүйтэй.

7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Газар зохион байгуулалт” магистр, докторын хөтөлбөрийн хороо магистр докторын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын төлөвлөгөөг (2021-2024 он) боловсруулж 2021 оны 02 сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Онцлог

- Газар зохион байгуулалт магистрын хөтөлбөрийг анх удаа магадлан итгэмжлэлд оруулж байгаа нь сайшаалтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	4	1	-	1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага "Газар зохион байгуулалт" магистрын хөтөлбөрт тусгагдсан 16 хичээлийн зөвхөн нэрийг гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрийн хичээлийн нэртэй харьцуулсан нь учир дутагдалтай байна.
2	Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	5	-	-	
3	Магистрантын суралцауйн үнэлгээ, хөгжил	7	1	-	3.4 Судалгааны санхүүжилт Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжилтийг төсөвтөө тусгадаггүй.
4	Багшлах бүрэлдэхүүн	4	-	-	
5	Нөөц ба санхүүжилт	3	-	-	
	Удирдлага ба мэдээллийн систем	3	1	-	6.3. Удирдлагын мэдээллийн систем ХААИС-ийн хувьд Удирдлагын мэдээллийн системийг бакалаврын болон ахисан түвшинд тус тусад нь ашиглаж байгаа нь сургалтын үйл ажиллагааг шуурхай, оновчтой, харилцан уялдаатай удирдан зохион байгуулахад хүндрэл үүсгэх магадлалтай.
7	Чанарын баталгаажуулалт	1	1	-	7.1 Чанарын баталгаажуулалт Чанарын удирдлага, зохицуулалтын алба нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийдэггүй. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл "Газар зохион байгуулалт" магистр, докторын хөтөлбөрийн хороо магистр докторын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын төлөвлөгөөг баталсан боловч түүний дагуу хэрэгжүүлсэн ажлын нотолгоогүй
	Нийт	27	4	-	
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Магистр, докторын сургуулийн “Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч Д.Гэрэлт-Од

Шинжээчийн багийн гишүүн Ж.Даваабаатар

Шинжээчийн багийн гишүүн.....С.Мөнхнаран

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ/ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ХААИС, МДС
Хөтөлбөрийн нэр	“Газар зохион байгуулалт”
Хөтөлбөрийн индекс	E07310101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. . Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	<p>1.2. Сургалтын төлөвлөгөөнд дэхь хичээлийг заавал болон сонгоны хичээлээр нь ялгаж тэмдэглэх.</p> <p>1.4 Хичээлийн агуулгыг шинэчилснээр гарсан үр дүн болон дадлагын хичээлийг лабораторийн хичээл болгож өөрчилснөөр гарсан үр дүнг бичих.</p> <p>1.5 Энд зөвхөн хичээлийн нэрээр харьцуулах биш, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон агуулгаар өөрөөр хэлбэл хөтөлбөрийг цогцоор нь гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулж улмаар “хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага” байх эсэхийг найивчлан судлах.</p>
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> Магистрант оюутны судалгааны ажлыг идэвхижүүлэх, магистрын суралцах хугацаанд хязгаар тавих, салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх грант төслүүдийг хэрэгжүүлэх, түүнд магистрант оюутнуудыг хамруулах зэргээр асуудлыг шийдэх боломжийг судлах нь зүйтэй.

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ,хөгжил	<p>3.4.</p> <ul style="list-style-type: none"> ГЗБ-ын магистрын хөтөлбөрийн хувьд сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг судлах Магистрант оюутныг удирдагч багш өөрийн удирдаж, оролцож буй олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний судалгааны төсөл, захилгат болон гэрээт ажилд татан оролцуулж хээрийн судалгаа хийх, судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлэхэд үзүүлсэн дэмжлэгийг профессор багшийн хөгжил, чадамжийн түвшинг үнэлэх шалгуурт оруулснаар багш болон магистрант оюутнуудын судалгааны ажлын идэвхижүүлэх, судалгааны санхүүжилийг шийдвэрлэдэг туршлагыг судлан хэрэгжүүлэх
Шалгуур 4. .Багшлах бүрэлдэхүүн	<ol style="list-style-type: none"> Олон улсын тэргүүлэх судлаач,эрдэмтэдийг урьж ажиллуулах Судалгаа үйлдвэрлэлийн институтийг түшиглэн магистрын судалгааны ажлыг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	<ol style="list-style-type: none"> ХААИС-ийн төсвийн төлөвлөлтөнд магистрын судалгааны ажил,грантыг буй болгох журам, дүрмийг боловсруулах судалгааны сургууль болох магистрын судалгааг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн ажиллах хэрэгтэй байна. Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх журмыг хэрэгжүүлэх. Лицензтэй програмын төлбөрийг их сургуулийн төсөвт тусгадаг байх
Шалгуур 6. .УМС	<ol style="list-style-type: none"> ГЗБ хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц, үйл ажиллагаа, бүрэлдэхүүний ажлын ур чадвар болон академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагын талаар дэлгэрэнгүй оруулах. Энэ шалгууртай холбоотой “Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлсэн” талаар нотлох баримт оруулах УМС-д байгаа бүх мэдээллийн жагсаалтыг гаргах. Их сургуулийн хэмжээнд нэдсэн нэг УМС хэрэглэж, тасралтгүй хөгжүүлэх 45-48 дугаар зургийн дотор байгаа цонхны нэрсийг тодруулах. Мэдээллийг ил тод байлгах түүний аюулгүй байдлыг хангах тухай заавар, журам боловсруулж мөрдөх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ol style="list-style-type: none"> “ХААИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажилтын журам” боловсруулж мөрдөх. Чанарын удирдлага,зохицуулалтын алба нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтад чиглэсэн бодитой ажил хийх Газар зохион байгуулалт хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг Агроэкологийн Сургуулийн болон тэнхимийн жил жилийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг үнэлж, хянах нь зүйтэй.
ШААРДЛАГА:	
1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнг гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгөх.
3. Магистрантын суралцахуйн	Судалгааны ажилд хангалттай санхүүжилтийг бий болгох

үнэлгээ,хөгжил	
6.УМС	УМС-ийг ашиглах, хянах, сайжруулах заавар журамтай болох
7.Чанарын баталгаажуулалт	Чанарын удирдлага,зохицуулалтын алба нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийдэг болох

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Багш нарын төлөлөл:

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1	Б.Баярмаа	ХААИС-ын ШУЗ-ийн ажлын албаны дарга	Судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих арга зүй	88020031
2	Ц.Эрдэнэбат	Ахлах багш	Судлаачийн ёсзүй	99262823
3	И.Лхам	Профессор багш		99143080
4	Г.Уянга	Ахлах багш		99031483
5	М.Мөнхзул	Дэд профессор багш		96052578
6	И.Мягмаржав	Дэд профессор багш	<ul style="list-style-type: none"> Газар зохион байгуулалтын судалгааны аргазүй Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ 	96651077
7	С.Сайнбаяр	Дэд профессор багш	<ul style="list-style-type: none"> Газрын тогтвортой менежмент Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтийн онол, аргазүй 	99057926
8	А.Буянбаатар	АЭС-ийн захирал	Хөрсний төлөв байдлын судалгааны арга	99014702
9	Л.Уранбилэг	Дэд профессор багш	<ul style="list-style-type: none"> Газар ашиглалт, төлөвлөлтийн онол, аргазүй Хот суурин газрын төлөвлөлтийн онол, аргазүй 	96006675
10	Д.Түвшинбаяр	ГМтэнхмийн эрхлэгч	<ul style="list-style-type: none"> Зайнаас тандан судлалын дэвшилтэт арга Газарзүйн мэдээллийн системийн орон зайн шинжилгээ 	99996904
11	Ч.Баасанжаргал	Ахлах багш	Газрын эрхзүйн дүн шинжилгээ	80089921
12	Ш.Гэрлээ	Дэд профессор багш	<ul style="list-style-type: none"> Газрын төлөв байдлын мониторинг Бэлчээрийн газрын төлөвлөлт 	99075199
13	Х.Мөнхтуяа	Дэд профессор багш	Усны нөөцийн менежмент	91183390

Оюутны төлөөлөл :

№	Магистрантын нэр	Амьдардаг газар	Утас	Цахим хаяг
1	Т.Болор	Улаанбаатар	99245191	AG17E016@mul.s.edu.mn
2	Н.Одончимэг	Улаанбаатар	88035936	AG19E036@mul.s.edu.mn
3	Нурбахыт	Баян-Өлгий	85112731	AG19E029@mul.s.edu.mn
4	О.Одбаяр	Улаанбаатар	80020394	AG19E203@mul.s.edu.mn
5	Г.Баянмөнх	Улаанбаатар	99956443	AG19E045@mul.s.edu.mn
6	Ж.Цэрэндолгор	Улаанбаатар	89712181	AG20E015@mul.s.edu.mn
7	Н.Еркежан	Улаанбаатар	99669928	AG20E005@mul.s.edu.mn
8	Д.Цэрэнханд	Өмнөговь	88900902	AG20E009@mul.s.edu.mn
9	Б.Гантогтох	Улаанбаатар	90901110	AG20E042@mul.s.edu.mn

10	А.Дүүрэнхишиг	Улаанбаатар	88981806	AG20E017@mul.s.edu.mn
11	Г.Дуламсүрэн	Хөвсгөл	86044499	AG20E046@mul.s.edu.mn

Төгсөгчдийн төлөөлөл:

№	Овог нэр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал	Утас
1	Ж.Урансайхан	2016	Газрын мэргэжлийн байгууллага	Захирал	99222100
2	Г.Эрдэнэбат	2016	Төв аймгийн ГХБХБГ	Газрын удирдлагын дарга	90099698, 80049698
3	Л.Отгонбаатар	2018	Нийслэлийн ИТХ	Төлөөлөгч	99110728
4	Б.Бадамгарав	2019	Төв аймгийн ГХБХБГ	ГЗБ-ч	88036289
5	Д.Мөнхбадрах	2019	“Харгуйн хурдатгал” ХХК	Менежер	90099904
6	О.Зоригт	2020	МГЗБХолбоо	Нарийн бичиг	94112161
7	Т.Болорцэцэг	2020	Хувиараа		80858596

Ажил олгогчдын төлөөлөл:

№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал	Утас	Цахим хаяг
1	М.Буяндэлгэр	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	Дэд дарга	88880099	
2	Г.Мөнхбаяр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Чөлөөлөлтийн хэлтэсийн дарга		
3	Г.Ариунсэлэнгэ	Говь-Алтай аймгийн ГХГЗЗГ	Газрын удирдлагын хэлтэсийн дарга	99143463	selengee39@gmail.com
4	Ш.Наран-Очир	“Вектор map” ХХК	Захирал	89039907	sh.naran-ochir@gmail.com
5	МГЗБХолбоо	Я.Баасандорж	УЗ-ын гишүүн	99092780	baasandorj_ya@yahoo.com
6	Б.Батсүрэн	МҮИС, Байгаль орчин хамгаалах технологийн тэнхим	Тэнхмийн эрхлэгч	96535858	batukmgl1030@gmail.com
7	Ц.Бадам	“Газар сервис” ХХК	Захирал	99006383	tbadam8888@gmail.com
8	М.Отгонбат	Төв аймгийн ГХБХБГ	Дарга		
9	Б.Батчимэг	ХУД-ийн ГЗБ-ын алба	Дарга	99056537	Batchimegbat1637@gmail.com
10	П.Содгэрэл	Дархан, ХААИС-ийн Агроинженерчлэлийн тэнхим	Тэнхмийн эрхлэгч	99372128	p.sodgerel2019@gmail.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ


17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Зайсан-5, Утас: 34 13 77, Факс: (976-11) 34 17 70,
И-мэйл: info@mul.s.edu.mn, Вэб сайт: www.mul.s.edu.mn

2021.11.19 № 1/415
танай _____ -ны № _____ -Т

БОЛОВСРОЛЫН
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Хариу хүргүүлэх тухай

“Газар зохион байгуулалт” магистрын хөтөлбөр /E07310101/-ийг магадлан итгэмжлүүлэхээр 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс ажилласан шинчээдийн багийн тайлантай танилцлаа. Манай хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчдийн үнэлгээг хүлээн зөвшөөрч байгааг энэхүү албан бичгээр мэдэгдэж байна.

АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛИЙН
ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ,
ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР  Д.ТҮВШИНБАЯР

